



ГОЛОМТ БАНКНЫ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 02 сарын 13-ны өдөр

Дугаар ...00/01

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 46.1, 46.2 дахь хэсэг, Голомт банкны дүрмийн 5 дугаар зүйлийн 5.3, 9 дүгээр зүйлийн 9.2.12 дэх хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн ээлжит бус хурлыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Голомт банкны 2025 оны үйл ажиллагааны ашгаас нэгж хувьцаанд 80 /наян/ төгрөгөөр тооцож, ногдол ашиг хуваарилахыг зөвшөөрсүгэй.
2. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах өдрийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдрөөр тасалбар болгон тогтоосугай.
3. Хууль журмын дагуу жижиг хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг Үнэт цаасны төлбөр тооцооны төвлөрсөн хадгаламжийн төв ТӨХК-иар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансаар дамжуулан зохицуулагч байгууллагын зөвшөөрөл ирснээс хойш Санхүүгийн зохицуулах хорооны журмын дагуу 2026 оны 4 дүгээр сард багтаан байршуулсугай.
4. Ногдол ашиг хуваарилахтай холбоотой бүхий л үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг Гүйцэтгэх захирал /А.Одонбаатар/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ч.МӨНХЦЭЦЭГ